



БЗДХ гэдэг нь халдвартай хэн нэгэн хvнээс бэлгийн харьцаагаар халддаг овчин юм. Мон үтрээгээр, шулуун гэдсээр, амаар бэлгийн харьцаанд орох нь халдвар дамжуулна.

- Жил бүр шинээр 15 сая БЗДХ-ын тохиолдол илэрч байна.
- 4 Америк хvний 1 нь амьдарлынхаа хугацаанд БЗДХ авсан байдаг.
- Насанд хvрэгчдийн /18-44 нас/ 50-с дээш хувь нь БЗДХ-ын шинжилгээнд огт хамрагдаагвй байдаг.
- Ихэнх хvмvvc БЗДХ-ын талаар мэддэгвй.

БЗДХ-ыг еронхийд нь 2 ангилдаг:

1. Вирусын шалтгаантай
2. Вирусын бус буюу бактер, эгэл биетний /protozoa/ гаралтай.

Вирусын бус БЗДХ-т трихомониаз, хламид, заг хvйтэн, тэмбvв ордог.

Вирусын гаралтай БЗДХ-т ХДХВ, герпес болон хvний папиллома вирусын халдварууд орно.

Трихомониаз гэж юу вэ?

Трихомониазын халдвар нь /заримдаа trich гэж нэрлэнэ/ хамгийн элбэг тохиолддог, нийт БЗДХ-тай эмэгтэйчvвдийн 1/3-ийг дээрх халдвар эзэлнэ. Бусад элбэг тохиолдох халдварууд нь бактерийн гаралтай үтрээний үрвэсэл болон моогонцорийн халдвар юм. Бактерийн гаралтай үтрээний үрвэсэл болон моогонцорийн халдвар нь бэлгийн замаар дамждагвй халдвар юм. БГҮҮ, моогонцор болон трихомониазаар эрэгтэй болон эмэгтэйчvвдийн аль аль нь ялгаагвй овчилно. Эмэгтэйчvвдэд эрэгтэйчvвдээс илvв эмнэл зvйн шинж тэмдэг тод илэрнэ. Эрэгтэйчvвд трихомониазын халдвар авсанаа огт мэддэгвй.

Трихомониаз нь нэг эст, шимэгчлэн амьдардаг эгэл биетэн юм. Халдвар нь эмэгтэйчvвдэд үтрээнд, эрэгтэйчvвдэд шээсний сvвэнд хамгийн тvгээмэл байрлана.

Хvмvvc трихомониазын халдвар авснаа яаж мэддэг вэ?

Трихомониаз нь бэлгийн замаар дамжина. бэлгийн харьцаанд орох вeд шодойноос үтрээнд эсвэл үтрээнээс гаднах нохон үржихvйн замаар буюу бэлгийн уруулаас бэлгийн

уруулд хврэлцэх замаар халдвар дамжина.Эмэгтэйчүүд халдвартай эрэгтэй эсвэл эмэгтэйгээс халдвар авдаг бол эрэгтэйчүүд ихэвчлэн халдвартай эмэгтэйгээс халдвар авдаг.Нийтийн дунд халдварыг оо-н суултуур, ванны нойтон алчуур, халуун усны газраас авч болдог гэсэн буруу ойлголт байдаг.Учир нь уг паразит нь гадаад орчинд удаан хугацаагаар амьдарч чаддаггүй.Трихомониазын гаралтай үтрээний үрэвслийн вед 1 жилийн турш шинж тэмдэг илрэхгүй явж болдог.

Трихомониазын тархалт

Трихомониаз бол бэлгийн идэвхитэй харьцаанд байдаг эмэгтэйчүүд болон залуучуудад хамгийн элбэг тохиолддог, эмчлэгддэг халдвар юм.АНУ-д жил бүр 7,4 сая шинэ халдвар эрэгтэй болон эмэгтэйчүүд авдаг гэсэн тооцоо байдаг.

Трихомониазын эмнэл зүйн шинж тэмдэг

Эмэгтэйд:

Хоосорхог, муудсан загасны үнэртэй, шар ногоон ялгадас үтрээнээс гарна.Гадна бэлэг эрхтэй үрэвсэж, загатнах, магадгүй заримдаа бэлгийн харьцаанд орох болон шээх вед хорсоно.Халдварын шинж тэмдэг нь халдвар авснаас хойш 5-28 дахь одорт илэрнэ.Зарим эмэгтэйчүүдэд ямарч шинж тэмдэг илэрдэггүй.

Эрэгтэйд:

Эрэгтэйчүүдэд илүү шинж тэмдэггүй байдаг.Зарим эрэгтэйд шээсний сүвний орчим үрэвсэх, шээх болон дур тавих вед хорсох, бага зэрэг ялгадас гарах шинж тэмдэг илэрнэ.Трихомониаз нь эрэгтэй болон эмэгтэйд ялгаагүй бэлгийн замаар дамжина.Моогонцор болон бактерийн халдвар нь эрэгтэйд шинж тэмдэггүй байдаг ба бэлгийн замаар дамждаггүй юм.

Трихомониазыг бактерийн гаралтай үтрээний үрэвсэлээс хэрхэн ялгах вэ?

Трихомониаз болон БГҮҮ-ийн вед илрэх ихэнх шинж тэмдэг нь адил байдаг.Иймээс та шаардлага хангасан эмнэлэгт ямар халдвар байгаа эсэхээ тодруулаад, зов эмчилгээг системтэй хийлгэх нь чухал.

Бусад бэлгийн замаар дамжих халдвартай юугаараа ялгаатай вэ?

Заг хүйтэн, хламидын вед ижил тостэй шинж тэмдэгүүд илэрнэ.Ихэнх эмэгтэйчүүдэд шинж тэмдэг илрэхгүй байж болно.Эрэгтэй болон эмэгтэйн аль алинд нь шар ялгадас гарах, шээх болон бэлгийн харьцаанд орох вед хорсох зовиур илэрнэ.Хламидын халдвартай эрэгтэйд шодойн орчимд загатнах, хорсох шинж тэмдэг байдаг.Заримдаа заг хүйтний халдвартай эрэгтэйд томсог хавдах, овдох шинж тэмдэг илэрнэ.Хүний папиллом вирус нь эрэгтэй болон эмэгтэйд аль алинд нь арьс болон нохон үржихүйн замд оорчлолт огдог ялангуяа эмэгтэйн умайн хүзүүнд хавдар үүсгэдэг.

Трихомониазаас оор ямар халдвар авснаа хэрхэн мэдэх вэ?

Халдвартай вед хэвийн биш ялгадас гардаг.Хэвийн ялгадас нь онгоггүй, үнэргүй, мэдэгдэх зовиургүй байдаг.Дээрх хэвийн байдал оорчлогдвол мэргэжлийн эмчид хандаж үзүүлэх хэрэгтэй.Бэлгийн идэвхитэй харьцаанд байдаг бол жилд нэг удаа заавал үзлэгт орох шаардлагатай юм.чамд ямар нэг халдвар байгаа бол санаа зоволтгүй эрүүл мэндийн байгууллагад хандах хэрэгтэй.Эмчийн бичсэн эмийн жороор эм авах нь хэцүү санагдах хэдий ч үүнээс илүү халдварын хор хоноол нь илүү гэдгийг санах хэрэгтэй.

Трихомониазыг эмчлэхгүй бол эрэгтэй болон эмэгтэйчүүдэд ялгаагүй олон янзын хор уршиг дагуулна.Трихомониаз нь ХДХВ-н тархалтыг нэмэгдүүлнэ, үргүйдлийг үүсгэнэ.Эмэгтэйчүүдэд умайн хүзүүний хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлнэ.Жирэмсэн вед дутуу торох эрсдэлтэй.

Эрэгтэйд трихомониаз нь шээсний сүвний болон түрүү булчирхайн хавдар үүсэх

эрсдэлтэй.

Трихомониазыг хэрхэн оношлох вэ?

Эрэгтэй эмэгтэйд ялгагч үзлэг болон лабораторын шинжилгээгээр оношилно. Үтрээний байдал болон ялгадсыг нүдээрээ харна. Үтрээний ялгадсаас наац бэлдэж микроскопт трихомонад шимэгчийг харж оношилно. Трихомониазтай вед үтрээний ялгадсанд цагаан эсийн хэмжээ нэмэгдэнэ. Сүвлийн вед трихомонадын rapid test буюу dip stick оношлогоо хийж байна. Энэ оношлогоо нь микроскоп ашигласнаас илүү хялбар хурдан арга юм. Гэвч энэ аргыг зөвхөн эмэгтэйчүүдэд хэрэглэнэ. Эсийн шинжилгээгээр БЗДХ илэрдэггүй, гэхдээ зарим вед трихомониазыг илрүүлж болдог. Трихомонад шимэгчийг эмэгтэйгээсээ илүү эрэгтэйд илрүүлэх нь их хэцүү байдаг.

Трихомониаз эмчлэгдэх үү?

Тийм. Эрэгтэй болон эмэгтэй аль аль нь тинидазол эсвэл метранидазолыг ууна. Жорговьгээр, лангуун дээрээс тосон түрхлэг, гел авч үтрээгээр хэрэглээд трихомониаз эмчлэгдэхгүй. Трихомониаз нь бэлгийн замын халдвар учраас бэлгийн хавьтагчтай заавал хамт эмчилж үр дүнд хүрнэ. Бэлгийн хавьтагчид шинж тэмдэггүй эсвэл шинж тэмдэг илрээд арилсан байсан ч заавал нэг зэрэг, ижил тунгаар эмчилгээг хамт хийнэ. Бүрэн эмчлэгдэх болон шинж тэмдэг бүрэн арилтал бэлгийн хавьтагчийн аль аль нь бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй.

Трихомониазаас урьдчилан сэргийлж чадах уу?

Тийм. Бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэх

Тохиолдлын бэлгийн харьцаанд орохгүй байх

Заг хүйтэн болон хламид

Заг хүйтэн болон хламидын халдвар нь бэлгийн зам, шулуун гэдэс, амаар дамжина. Энэхүү халдварууд нь шинэ торсон нярайд нүдний салстаар дамжин халдварлана. эмэгтэйд халдварын үүсгэгч нь умайн хүзүүнд байрлана. Улмаар халдвар нь умай болон үрийн гуурсан хоолойд тархана.

Халдварын шинж тэмдэг

Заг хүйтэн болон хламид нь ихэвчлэн шинж тэмдэггүй байдаг. Халдвар авснаас хойш 2 хоногос 3 долоо хоногийн хооронд шинж тэмдэг илэрнэ.

Эмэгтэйд түгээмэл илрэх шинж тэмдэг:

- Үтрээнээс шар ялгадас гарах, загатнах
- Олон дахин шээх, шээхэд хорсох
- Бэлгийн уруул улайх, хавдах, үрэвсэх
- Бэлгийн харьцаанд орох вед хэвлийн доогуур овдох
- Мочлоггүй цус гарах
- Шулуун гэдэснээс цус болон эмгэг ялгадас гарах, хорсох

Эрэгтэйд түгээмэл илрэх шинж тэмдэг:

- Шээсний сүвнээс ялгадас гарах
- Шээхэд шээсний сүвээр хорсох, овдох
- Шулуун гэдэснээс цус гарах, хорсох

Оношлогоо

Эмч үзлэг хийн улаан хоолой, умайн хүзүү, шээсний сүв болон бусад халдвартай байж болох хэсгүүдээс сорьц авна. Ийм маягаар бусад холбогдох шинжилгээнүүдийг хийж оношилно.

Эмчилгээ

Заг хүйтэн болон хламидын халдварыг антибиотикоор эмчилнэ. Энэ тухай мэдээлэл танай

харъяалалын эмнэлэгт байдаг.бэлгийн хавьтагчаа заавал хамт эмчлүүлнэ.бэлгийн хавьтагчийн аль аль нь эмчилгээ дуустал бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй. Загхвйтэн болон хламидын халдварыг сорог үр дагавар

- Бага аарцгийн эрхтэний үрэвсэлт овчин үүсгэнэ /умай, үрийн хоолой, ондговч гм/. Үүнээс шалтгаалаад үргвйдэлд хүргэнэ.ихэнх эмэгтэйчүүдэд бага аарцгийн үрэвсэлт эмгэг болох хүртлээ ямар нэг шинж тэмдэггүй байдаг.
- Умайн гаднах жирэмсэн.бага аарцгийн үрэвсэлт эмгэгээс үрийн хоолойд наалдац үүсдэг.Үрийн хоолой бүхлээрээ болон хэсэгчлэн наалдац үүссэн байдаг.Иймээс үр тогтсон ондгон эс умайд бэхлэгдэж чаддаггүй.

Тэмбүү

Тэмбүү нь үе шаттай явагддаг эмгэг юм.Тэмбүүг эмчлэхгүй бол зүрх, цусны судас, мэдрэлийн системийг гэмтээдэг.Даамжирвал тархины эдийн гэмтэл, сохрох, саажилт үүсэх цаашлаад үхэлд ч хүргэж болно.

Шинж тэмдэг

Овчин эмзэглэлгүй шанкр гэж нэрлэгдэх хатуу яр гарна.Халдвар авснаас хойш 10 одроос 6 долоо хоногийн дараа шинж тэмдэг илэрнэ.Заримдаа цавь орчмын тунгалагын булчирхай томроно.Эмчлэхгүй бол 1 долоо хоногоос 3 сарын дараа холийн ул болон гарын алган дээр тууралт гарна.Бэлгийн уруул болон үтрээний орчмоор хатуу яр гарна, ханиад амархан хүрэх ба энэ шатанд халдварлах чадвар маш ондор байдаг.Тууралт нь хэдэн долоо хоногоос хэдэн сарын дараа алга болно.Энэ үеийг далд үе гэнэ.Жилийн дараа магадгүй овчин дахин сэдрэнэ.

Тэмбүү хэрхэн тархдаг вэ?

Тэмбүү нь халдварлагдсан цусаар, бэлгийн замаар, хатуу яртай нягт хүрэлцэх үед халдвар дамжина.Мон зүсэгдсэн арьсаар халдвар дамжина.

Оношлогоо

Эрт шатанд нь яр, шархнаас шинжилдгэ авч үүсгэгчийн илрүүлнэ.Овчтоний цуснаас шинжилгээ авна.Мон бусад БЗДХ байгаа эсэхийг тодруулна.

Эмчилгээ

Тэмбүүг антибиотикоор эмчилнэ.Эмчилгээг эрт эхлэх тусам цаашдын хүндрэлээс сэргийлнэ.Бэлгийн хавьтагчтай хамт эмчилнэ.Эмчилгээ дуустал бэлгийн харьцаанд орохгүй.

Хэн тэмбүүгийн халдвар авах эрсдэлтэй вэ?

- Олон бэлгийн хавьтагчтай
- Эрт бэлгийн харьцаанд орох
- Бусад ямар нэг БЗДХ-тай байх
- Мансууруулах бодис хэрэглэгч

Жирэмсэн эмэгтэй халдвар авсан үед гарах эрсдэлүүд:

Хэрэв жирэмсэн үед заг хвйтэн, хламид, тэмбүүгийн халдвар авсан бол чамд болон олон асуудлууд тулгарна.

Үүнд:

- Дутуу торох / 37 долоо хоногоос олно торох /
- Ураг орчмын шингэн урьтаж гарах
- Зулбах
- Торсон нярайд нүдний халдвар үүснэ.Мон хараагүй болох эрсдэлтэй байдаг.
- Уушигний үрэвсэл
- Ургийн торолхийн гажиг

- Ураг амьгвй болох зэрэг хвндрэлвуд гарна.

Иймээс жирэмсэн эмэгтэйчвуд тэмбvvгийн шинжилгээ заавал огох хэрэгтэй.Мон заг хвйтэн болон хламидын шинжилгээг огох хэрэгтэй.Халдвартай бол эмчлvvлэх нь чухал.

Урьдчилан сэргийлэх

- Олон бэлгийн хавьтагчгвй байх
- Бэлгийн хавьтагчийнхаа омнох бэлгийн амьдралын талаар асуух, омно нь БЗДХ авч байсан эсэхийг тодруулах, бэлгийн хавьтагчид ямар нэг шинж тэмдэг илрээгвй ч халдвартай байж магадгвй гэдгийг санах
- Тогтмол бэлгэвч хэрэглэх
- Шулуун гэдэс болон амаар бэлгийн харьцаанд орохгвй байх

Эцэст нь хэлэхэд...

Та магадгвй заг хвйтэн, хламид, тэмбvvгийн халдвар авсан байх эрсдэлтэй гэж бодож байгаа бол шинжилгээ ог. Эдгээр овчнvvдийг эрт хугацаанд оношилж эмчилбэл хор уршиг багатай байдаг.